



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/08/СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: daqvasurenb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330
Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Аудитор Ц.Оюунсүвд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

додд. 03-дг № 1302/466

танай _____ -ны № _____ -т

ИХ-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА О.ОДОНТУЯА-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Audit(D)A4-тоот/2022

013025535

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,214,861,986.88</u>	<u>1,423,556,042.61</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	460,154,218.29	438,685,454.99
312	Банканд байгаа бэлэн мөнгө	460,154,218.29	438,685,454.99
3121	Төгрөг	460,154,218.29	438,685,454.99
31211	Төрийн сангийн харилцах	457,672,945.29	435,076,007.99
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	2,481,273.00	3,609,447.00
33	АВЛАГА	266,674,946.00	418,527,745.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,357,531.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага		120,351,720.00
335	Бусад авлага	265,317,415.00	298,176,025.00
3351	Байгууллагаас авах авлага	-	30,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	265,317,415.00	268,176,025.00
35	БАРАА МАТЕРИАЛ	488,032,822.59	566,342,842.62
351	Түүхий эд материал	182,034,856.85	206,090,563.43
35110	Тусгай зориулалттай материал	160,037,510.98	181,581,490.14
35130	Эм боох материал	21,997,345.87	24,509,073.29
35300	Бэлэн бүтээгдэхүүн		2,565,350.00
354	Хангамжийн материал	299,212,365.74	350,848,929.19
35410	Бичиг хэргийн материал	5,682,645.00	7,106,745.00
35420	Аж ахуйн материал	214,558,943.14	250,478,324.19
35430	Сэлбэг хэрэгсэл	-	320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	40,099,491.00	71,323,870.00
35450	Барилгын засварын материал	1,521,000.00	2,642,000.00
35460	Хүнсний материал	31,836,486.60	13,464,190.00
35470	Бусад хангамжийн материал	5,513,800.00	5,513,800.00
35600	Мал амьтад	6,785,600.00	6,838,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,748,253,776.62</u>	<u>6,297,587,153.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,748,253,776.62	6,297,587,153.91
392	Биет хөрөнгө	5,570,135,401.68	6,121,519,779.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,184,178,670.72	5,793,647,855.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(541,325,349.12)	(692,030,421.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	546,875,282.50	455,754,982.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(299,781,833.37)	(246,250,931.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	871,756,155.25	917,138,689.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(697,940,973.90)	(651,479,722.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	363,138,755.33	423,887,874.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(204,354,578.60)	(236,997,771.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	400,949,594.44	430,639,594.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	(150,476,760.42)	(177,770,856.64)
39217	Ном	97,116,438.85	104,980,486.85
393	Биет бус хөрөнгө	178,118,374.94	176,067,374.90
39301	Програм хангамж	11,692,000.00	11,692,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,401,625.06)	(5,452,625.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	169,828,000.00	169,828,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,963,115,763.50</u>	<u>7,721,143,196.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>16,574.00</u>	<u>73,822,645.78</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,574.00	73,822,645.78
413	Өглөг	16,574.00	73,822,645.78
4136	Бусад өглөг	16,574.00	73,822,645.78
41361	Байгууллагад төлөх өглөг	16,574.00	49,702,602.78
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		24,120,043.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,963,099,189.50</u>	<u>7,647,320,550.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,963,099,189.50	7,647,320,550.74

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,784,576,462.85	2,784,576,462.85
51101	Өмч: - төрийн	2,784,576,462.85	2,784,576,462.85
512	Хуримтлагдсан үр дүн	2,978,002,330.83	3,667,971,474.15
51210	Өмнөх үеийн үр дүн	622,868,889.59	3,007,000,022.91
51220	Тайлант үеийн үр дүн	2,355,133,441.24	660,971,451.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,200,520,395.82	1,194,772,613.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,963,115,763.50</u>	<u>7,721,143,196.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,371,155,828.11	6,499,104,458.86
11	ТАТВАРЫН ОРЛОГО	393,434,106.81	208,292,386.94
110	Орлогын албан татвар	115,158,941.46	91,766,043.96
1100	Хувь хүний орлогын албан татвар	115,158,941.46	91,766,043.96
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	48,000.00	
110002	Үйл ажиллагааны орлого	55,599,558.40	25,126,278.34
110003	Хөрөнгийн орлого	58,335,833.06	62,488,853.62
110004	Хөрөнгө борлуулсны орлого	1,175,550.00	4,150,912.00
113	Хөрөнгийн албан татвар	2,251,800.00	27,109,550.00
113002	Бууны албан татвар	2,251,800.00	3,430,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		23,679,550.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	276,023,365.35	89,416,792.98
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,363,144.09	8,145,882.12
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,961,644.09	5,241,843.12
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,001,500.00	2,011,856.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	400,000.00	892,183.00
1181	Газрын төлбөр	413,066.00	365,354.00
118101	Газрын төлбөр	413,066.00	365,354.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	266,247,155.26	80,905,556.86
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	53,681,669.26	76,616,038.86
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	351,000.00	269,668.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	198,000.00	403,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	212,016,486.00	3,616,850.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,519,042,628.30	1,031,438,029.38
120	Нийтлэг татварын бус орлого	2,519,042,628.30	1,028,134,029.38
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	4,147,768.87	40,964,366.00
120003	Торгуулийн орлого	10,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,311,554,069.77	52,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,311,554,069.77	52,400.00
120009	Бусад орлого	33,862,989.00	
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	154,401,872.90	765,198,659.44
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	15,065,927.76	221,918,603.94
121	Хөрөнгийн орлого	-	3,304,000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		3,304,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,458,679,093.00	5,259,374,042.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,836,226,100.00	3,023,031,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,836,226,100.00	3,023,031,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,459,696.00	345,056,961.54

**Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,460,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,651,296.00	270,355,112.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,348,000.00	74,701,849.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,480,250,485.00	1,664,423,307.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	756,791,000.00	892,992,660.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	14,124,490.00	28,194,926.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	609,113,300.00	563,162,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	100,221,695.00	180,072,921.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	54,742,812.00	226,862,174.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	54,742,812.00	226,862,174.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,916,518,840.87	5,739,543,820.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,916,518,840.87	5,739,543,820.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,976,134,933.87	4,467,255,841.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,657,024,232.00	2,838,125,964.00
210101	Үндсэн цалин	2,030,770,797.22	1,833,147,202.00
210102	Нэмэгдэл	195,356,197.01	758,907,865.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,193,000.00	7,005,000.00
210104	Урамшуулал	314,097,692.77	194,375,068.00
210105	Гэрээт ажлын хөлс	109,606,545.00	44,690,829.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	332,159,655.00	363,376,361.90
210201	Тэтгэврийн даатгал	229,705,691.00	253,747,570.90
210202	Тэтгэмжийн даатгал	27,070,757.00	28,060,958.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,401,180.00	23,070,631.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,879,794.00	5,293,507.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,102,233.00	53,203,695.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196,955,624.00	168,752,858.00
210301	Гэрэл, цахилгаан	21,837,008.00	31,932,314.00
210302	Түлш, халаалт	174,903,616.00	136,416,944.00
210303	Цэвэр, бохир ус	215,000.00	403,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	117,620,511.70	152,771,590.77
210401	Бичиг хэрэг	14,371,958.00	25,203,471.82
210402	Тээвэр, шатахуун	69,373,850.70	71,525,297.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,089,422.00	4,902,150.00
210404	Ном, хэвлэл	148,920.00	479,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,636,361.00	50,631,171.95
2105	Нормативд зардал	130,725,292.65	390,930,521.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,514,228.65	309,769,515.02
210502	Хоол, хүнс	79,535,064.00	79,577,506.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	676,000.00	1,583,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,534,550.00	12,131,630.00
210604	Урсгал засвар	6,534,550.00	12,131,630.00
2107	Томилолт, зочны зардал	8,941,800.00	13,767,300.00
210702	Дотоод албан томилолт	8,941,800.00	13,767,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,077,542.00	60,413,714.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,464,441.00	55,025,809.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,100.00	3,888,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	285,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,600.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,612,021.00	129,621.00

**Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	417,500.00	411,184.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,080.00	60,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	466,095,726.52	466,985,901.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,980,955.00	119,883,436.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,002,427.45	27,924,635.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	420,112,344.07	319,177,829.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	940,383,907.00	1,272,287,979.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,399,150.00	174,584,228.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,639,900.00	60,122,210.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,028,700.00	50,734,362.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,360,550.00	17,437,656.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	370,000.00	46,290,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	777,625,250.00	1,049,383,194.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	756,791,000.00	892,992,660.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,124,490.00	123,594,926.00
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,709,760.00	32,795,608.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,359,507.00	48,320,557.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,359,507.00	48,320,557.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,454,636,987.24</u>	<u>759,560,638.03</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	99,503,546.00	98,589,186.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	18,380,952.79
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	99,503,546.00	80,208,234.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(99,503,546.00)	(98,589,186.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,355,133,441.24</u>	<u>660,971,451.24</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,784,576,462.85	1,200,520,395.82	622,858,715.59	4,607,955,574.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	10,174.00	10,174.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,784,576,462.85	1,200,520,395.82	622,868,889.59	4,607,965,748.26
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,355,133,441.24	2,355,133,441.24
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,784,576,462.85	1,200,520,395.82	2,978,002,330.83	6,963,099,189.50
D01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,784,576,462.85	1,200,520,395.82	2,978,002,330.83	6,963,099,189.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-5,747,782.08	28,997,692.08	23,249,910.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,784,576,462.85	1,194,772,613.74	3,007,000,022.91	6,986,349,099.50
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	660,971,451.24	660,971,451.24
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,784,576,462.85	1,194,772,613.74	3,667,971,474.15	7,647,320,550.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,953,810,908.68</u>	<u>5,552,390,001.48</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	393,434,106.81	208,292,386.94
110	Орлогын албан татвар	115,158,941.46	91,766,043.96
1100	Хувь хүний орлогын албан татвар	115,158,941.46	91,766,043.96
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	48,000.00	
110002	Үйл ажиллагааны орлого	55,599,558.40	25,126,278.34
110003	Хөрөнгийн орлого	58,335,833.06	62,488,853.62
110004	Хөрөнгө борлуулсны орлого	1,175,550.00	4,150,912.00
113	Хөрөнгийн албан татвар	2,251,800.00	27,109,550.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		
113002	Бууны албан татвар	2,251,800.00	3,430,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		23,679,550.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	276,023,365.35	89,416,792.98
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,363,144.09	8,145,882.12
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,961,644.09	5,241,843.12
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,001,500.00	2,011,856.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	400,000.00	892,183.00
1181	Газрын төлбөр	413,066.00	365,354.00
118101	Газрын төлбөр	413,066.00	365,354.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	266,247,155.26	80,905,556.86
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	53,681,669.26	76,616,038.86
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	351,000.00	269,668.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	198,000.00	403,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	212,016,486.00	3,616,850.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,697,708.87	205,075,292.00
120	Нийтлэг татварын бус орлого	101,697,708.87	205,075,292.00
120002	Хүүгийн орлого	1,135,653.87	34,003,982.00
120003	Торгуулийн орлого	10,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,689,066.00	171,071,310.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,689,066.00	171,071,310.00
120009	Бусад орлого	33,862,989.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,458,679,093.00	5,139,022,322.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,836,226,100.00	3,023,031,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,836,226,100.00	3,023,031,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,459,696.00	345,056,961.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,460,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,535,996.00	270,355,112.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,463,300.00	74,701,849.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,480,250,485.00	1,664,423,307.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	756,791,000.00	892,992,660.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	14,124,490.00	28,194,926.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	609,113,300.00	563,162,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	100,221,695.00	180,072,921.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	54,742,812.00	106,510,454.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	54,742,812.00	106,510,454.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,487,781,053.00</u>	<u>5,243,132,650.78</u>

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,487,781,053.00	5,243,132,650.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,547,267,146.00	3,968,411,321.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,647,493,584.00	2,822,516,917.90
210101	Үндсэн цалин	2,008,771,623.22	1,850,895,047.90
210102	Нэмэгдэл	456,523,089.27	716,786,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,306,476.75	7,383,900.00
210104	Урамшуулал	144,252,767.76	219,174,091.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,639,627.00	28,277,413.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,992,466.00	377,212,252.00
210201	Тэтгэврийн даатгал	236,307,546.00	265,961,491.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,016,388.00	28,486,072.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,361,826.00	22,581,677.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,996,441.00	5,537,950.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,310,265.00	54,645,062.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,566,904.00	202,022,040.00
210301	Гэрэл, цахилгаан	22,637,008.00	31,522,970.00
210302	Түлш, халаалт	157,514,896.00	168,105,470.00
210303	Цэвэр, бохир ус	1,415,000.00	2,393,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,195,834.00	115,932,316.82
210401	Бичиг хэрэг	16,956,798.00	20,869,771.82
210402	Тээвэр, шатахуун	64,249,649.00	62,846,895.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,148,297.00	7,220,150.00
210404	Ном, хэвлэл	168,320.00	479,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,141,050.00	1,853,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,531,720.00	22,662,600.00
2105	Нормативд зардал	104,951,855.00	152,707,112.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,953,300.00	88,478,142.72
210502	Хоол, хүнс	59,246,655.00	53,546,770.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,751,900.00	10,682,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,699,100.00	24,833,530.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,352,100.00	8,952,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	983,300.00	1,043,200.00
210604	Урсгал засвар	11,363,700.00	14,838,230.00
2107	Томилолт, зочны зардал	12,813,500.00	13,767,300.00
210702	Дотоод албан томилолт	12,813,500.00	13,767,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,181,712.00	149,683,865.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,568,611.00	143,845,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,100.00	3,888,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	285,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,600.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,612,021.00	129,621.00
210807	Газрын төлбөр	417,500.00	411,184.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,080.00	60,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,372,191.00	109,735,987.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,488,081.00	69,101,172.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,884,110.00	40,634,815.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	940,513,907.00	1,274,721,329.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,529,150.00	177,017,578.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,639,900.00	62,555,560.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,028,700.00	50,734,362.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,360,550.00	17,437,656.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	46,290,000.00

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	777,625,250.00	1,049,383,194.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	756,791,000.00	892,992,660.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,124,490.00	123,594,926.00
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,709,760.00	32,795,608.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,359,507.00	48,320,557.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,359,507.00	48,320,557.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>466,029,855.68</u>	<u>309,257,350.70</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	109,583,546.00	191,931,734.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,583,546.00	191,931,734.00
2200	Дотоод эх үүсвэрээр	109,583,546.00	191,931,734.00
223001	Бусад хөрөнгө	99,503,546.00	80,208,234.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,080,000.00	111,723,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(109,583,546.00)</u>	<u>(191,931,734.00)</u>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	52,855,100.00	138,794,380.00
230001	Эргэж төлөгдөх зээл	52,855,100.00	138,794,380.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(52,855,100.00)</u>	<u>(138,794,380.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	303,591,209.68	(21,468,763.30)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	156,563,008.61	460,154,218.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	460,154,218.29	438,685,454.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны	
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,696,634,561.00	4,403,208,400.00	4,109,741,679.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,544,275,915.00	4,015,075,400.00	3,890,739,065.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,476,107,315.00	3,951,028,100.00	3,826,693,505.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,641,493,584.00	2,813,546,700.00	2,795,094,018.90
210101	Үндсэн цалин	2,002,771,623.22	1,929,813,800.00	1,843,622,148.90
210102	Нэмэгдэл	456,523,089.27	635,427,000.00	716,786,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,306,476.75	9,096,000.00	7,383,900.00
210104	Урамшуулал	144,252,767.76	178,630,800.00	199,024,091.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,639,627.00	60,579,100.00	28,277,413.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,992,466.00	379,829,100.00	376,187,852.00
210201	Тэтгэврийн даатгал	236,307,546.00	267,286,900.00	264,937,091.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,016,388.00	28,135,600.00	28,486,072.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,361,826.00	22,508,500.00	22,581,677.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,996,441.00	5,627,100.00	5,537,950.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,310,265.00	56,271,000.00	54,645,062.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,196,904.00	205,831,100.00	202,022,040.00
210301	Гэрэл, цахилгаан	22,637,008.00	22,526,900.00	31,522,970.00
210302	Түлш, халаалт	161,144,896.00	178,913,600.00	168,105,470.00
210303	Цэвэр, бохир ус	1,415,000.00	4,390,600.00	2,393,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,018,014.00	107,280,000.00	106,636,941.00
210401	Бичиг хэрэг	17,006,698.00	17,562,500.00	18,727,396.00
210402	Тээвэр, шатахуун	49,852,229.00	56,383,100.00	55,618,395.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,422,147.00	11,429,100.00	7,220,150.00

**Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,412,300.00	1,853,400.00	1,853,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,860,400.00	12,889,300.00	21,988,100.00
2105	Нормативд зардал	89,978,955.00	111,326,400.00	88,642,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,980,400.00	28,671,200.00	28,668,000.00
210502	Хоол, хүнс	59,246,655.00	71,972,300.00	49,292,420.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,751,900.00	10,682,900.00	10,682,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,069,100.00	25,740,600.00	25,689,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,352,100.00	15,352,100.00	15,352,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	983,300.00	1,043,200.00	1,043,200.00
210604	Урсгал засвар	7,733,700.00	9,345,300.00	9,294,630.00
2107	Томилолт, зочны зардал	12,813,500.00	14,974,900.00	13,536,300.00
210702	Дотоод албан томилолт	12,813,500.00	14,974,900.00	13,536,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,316,901.00	186,691,000.00	118,535,375.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,173,700.00	180,204,200.00	112,697,470.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,100.00	4,161,000.00	3,888,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	539,100.00	539,100.00	539,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	295,700.00	285,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,600.00	88,600.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,142,121.00	203,400.00	129,621.00
210807	Газрын төлбөр	417,500.00	688,300.00	411,184.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,080.00	60,700.00	60,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,227,891.00	105,808,300.00	100,348,429.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,343,781.00	53,264,100.00	47,854,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,884,110.00	52,544,200.00	52,493,869.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,168,600.00	64,047,300.00	64,045,560.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,168,600.00	64,047,300.00	64,045,560.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,639,900.00	62,557,300.00	62,555,560.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,028,700.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,490,000.00	1,490,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,503,546.00	246,384,200.00	80,208,234.00
2200	Дотоод эх үүсвэрээр	99,503,546.00	246,384,200.00	80,208,234.00
223001	Бусад хөрөнгө	99,503,546.00	246,384,200.00	80,208,234.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	52,855,100.00	141,748,800.00	138,794,380.00
230001	Эргэж төлөгдөх зээл	52,855,100.00	141,748,800.00	138,794,380.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,711,186,676.00	4,403,208,400.00	4,241,883,307.66
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,746,866,593.00	3,013,057,800.00	2,974,711,042.66
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,746,866,593.00	3,013,057,800.00	2,974,711,042.66
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	842,888,205.00	896,384,200.00	1,044,870,655.00
122005	Орон нутгийн төсвөөс	742,666,510.00	716,311,200.00	864,797,734.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	100,221,695.00	180,073,000.00	180,072,921.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,742,812.00	56,118,500.00	51,230,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	54,742,812.00	56,118,500.00	51,230,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	66,689,066.00	437,647,900.00	171,071,310.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,689,066.00	90,000,000.00	171,071,310.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		347,647,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,507,915.90	-	98,060,030.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,060,030.90	-	230,201,658.66
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,179.00	2,181.00	2,179.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	7.00	7.00

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

610001	Төсвийн байгууллага	7.00	7.00	7.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	232.00	233.00	232.00
620001	Удирдах ажилтан	15.00	15.00	15.00
620002	Гүйцэтгэх ажилтан	142.00	140.00	140.00
620003	Үйлчлэх ажилтан	71.00	74.00	73.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,708.00	1,708.00	1,708.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,365.00	1,365.00	1,365.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,365.00	1,365.00	1,365.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	343.00	343.00	343.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	343.00	343.00	343.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	232.00	233.00	232.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00	6.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	162.00	162.00	162.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	11.00	11.00	11.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	27.00	28.00	28.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	12.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	343,928,787.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	343,928,787.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	198,161,161.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	27,422,899.00
210101	Үндсэн цалин		7,272,899.00
210104	Урамшуулал	-	20,150,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	1,024,400.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,024,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	10,045,375.82
210401	Бичиг хэрэг		2,142,375.82
210402	Тээвэр, шатахуун	-	7,228,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		674,500.00
2105	Нормативд зардал	0.00	15,142,400.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	10,888,050.72
210502	Хоол, хүнс	-	4,254,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	5,543,600.00
210604	Урсгал засвар		5,543,600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	231,000.00
210702	Дотоод албан томилолт	-	231,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	92,458,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		92,458,490.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	46,292,996.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	36,088,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,204,446.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	145,767,626.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	112,972,018.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		50,734,362.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		17,437,656.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	44,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	32,795,608.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		32,795,608.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,128,174.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	345,056,961.54
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	270,355,112.54
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		74,701,849.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		1,128,174.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,481,273.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,609,447.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, үндсэн үүргээ мөрдлөг болгон, УИХ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудаас гаргасан тогтоол шийдвэр, заавар журам, албан даалгаврыг хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хийж хэрэгжүүлэхээр зорилтуудыг биелүүлэх зорилго, зорилт, чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сум нь дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 5,552.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 83.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 62.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 438.7 сая төгрөг болж өмнөх оноос 21.4 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 84.0 сая төгрөг нь СХС-ийн 146.2 сая төгрөг нь ОНХС-ийн, 2.6 сая төгрөг нь бусад сан, 0.98 сая төгрөг нь сумын ЭМТ-ийн, 204.9 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлага дансны үлдэгдэл 418.5 сая төгрөг болж өмнөх оноос 151.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд үүссэн авлага, ЗДТГ-ын авлага 31.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЗДТГ	31,188,606.00	62,607,800.00
ЭМТ	-	123,655,720.00
Цэцэрлэг	674,167.00	-
Соёлын төв	147,358.00	-
СХС	234,664,815.00	232,264,225.00
ОНХС	-	16,000,000.00
ДҮН	266,674,946.00	418,527,745.00

Илрүүлэлт: ТШЗ-ын санхүүгийн аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 46.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 566.3 сая төгрөг болж, өмнөх оноос 78.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь түүхий эд материал 24.1 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 2.6 сая төгрөгөөр, хангамжийн материал 51.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 6,297.6 сая төгрөг болж 549.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ЗДТГ, ЕБС, Цэцэрлэгүүд 111.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ЭМТ, Соёлын төв, ЕБС, Цэцэрлэгт 83.6 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, ЗДТГ-т 691.6 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн, элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөг дансны үлдэгдэл 73.8 сая төгрөг болж өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвд үүссэн өглөг байна.

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭМТ	-	73,822,645.78
СХС	16,574	-
ДҮН	16,574	73,822,645.78

/төгрөгөөр/

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 7,647.3 сая төгрөг болж 684.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 4,670.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж, 267.6 сая төгрөгөөр бууруулж, 4,403.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 4,403.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4,015.1 сая төгрөгийг урсгал зардалд, 246.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 141.7 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3,013.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 716.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 56.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 180.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 90.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 346.7 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,974.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 864.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 51.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 180.1 сая төгрөг, нийт 4,241.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 161.3 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 171.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс зээл 29.4 сая төгрөгөөр нэмж төлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,482.3 сая төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 28.2 сая төгрөгийг сумын төсөвт, 48.3 сая төгрөгийг улсын төсөвт, 95.4 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 264.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 74.7 сая, нийт 345.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 311.1 сая зарцуулж, үлдэгдэл 32.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс бага тул зөрчилгүй санал, дүгнэлт өгсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс 146 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 6 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 18.71 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4.95 сая төгрөгийн алдааг залруулж, 13.76 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Төвийн шууд захирагчийн тайланг нэгтгэхдээ 2 дугаар цэцэрлэгийн аудитлагдсан тайланг 4.95 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг залруулсан.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал Нярвын хувийн дансаар мөнгө дамжуулан зарцуулсан, анхан шатны баримт дутуу ажил гүйлгээ гаргасан, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, зардлыг зориулалт бус зарцуулсан, ЗГ-ын 43 дугаар тогтоолыг зөрчиж, ажилчдад хүүхдийн баярын бэлэг олгосон зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	5	42.5	2	15.8			1	4.8	2	21.9
2	Эрүүл мэндийн төв	5	48.9	3	2.0	2	46.9				
3	1 дүгээр цэцэрлэг	6	18.9	5	18.5					1	0.4
4	2 дугаар цэцэрлэг	4	2.5	2	0.9					2	1.6
5	Ерөнхий боловсролын сургууль	2	128.7							2	128.7
7	Төвлөрүүлэн захирагч	2	18.71	1	4.95					1	13.76
Дүн		24	260.2	13	42.2	2	46.9	1	4.8	8	166.4